



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/354

Мандалговь

2021 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага
явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны мн/203 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны н/131 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2021 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Товчооны дарга:	Л.Доржбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Орлогч дарга:	Ш.Гансүх (Цэргийн штабын дарга, дэд хурандаа)
Нарийн бичгийн дарга:	Г.Цэрэндолгор (ЦШ-ын тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа)
Гишүүдэд:	Х.Жаргал (Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч) Ц.Баттулга (Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, дэд хурандаа)

2. 2021 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 10 дүгээр сарын 01-наас 10 дугаар сарын 13-ны өдрүүдэд Гурвансайхан, Өлзийт, Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан сумдад зохион байгуулалтын өндөр түвшинд явуулсугай.

3. Цэрэг татлагын товчоонд даалгах нь:

а/. "COVID-19"-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын Х хуралдааны тэмдэглэлийг үндэслэн улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарласан тул цэрэг татлагыг зохион байгуулахдаа сумдыг баг тус бүрээр нь 5-аас дээшгүй залуучуудыг нэг дор оруулах, хүн тус бүрийн хооронд 1.5 метрээс 2 метрийн зайд зогсоох, тус үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг чанд сахиж, улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэрийг чанд мөрдөж ажиллах;

б/. Монгол Улсын Засгийн газраас тогтоосон ээлж, хугацаанд цэрэг татлагыг зохион байгуулан явуулж, Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн хяналтын тоог биелүүлэх;

481215162

в/. цэргийн жинхэнэ албанд татагдах насны иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийх;

г/. цэрэг татлагын товчоо нь иргэнийг Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"- ийн 16.2, Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"- заасныг үндэслэн цэргийн жинхэнэ албанд татахаас тухайн жил түр чөлөөлөх;

д/. иргэнээс цэрэг татлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох хуулийн дагуу хянан, шуурхай шийдвэрлэх, цэрэг татлагын үед иргэний үүргээ биелүүлээгүй иргэд, албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ тооцож ажиллах;

е/. 1971-1994 оны цэргийн албыг ямар нэгэн төрлөөр хаагаагүй залуучуудыг Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл, 2009 оны "УИХ-ын 33 дугаар тогтоол" Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын дагуу мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах төлбөрийн хэмжээг тооцож мөнгөн төлбөрийг төлүүлэх;

ё/. цэргийн албанд тэнцсэн иргэнийг цэргийн жинхэнэ алба хаалгах шийдвэр гаргаж, цэргийн анги, байгууллагад хуваарилах, Зэвсэгт хүчний Жанжин Штабаас өгсөн хяналтын тооны дагуу гэрээт цэргийг журмын дагуу сонгон авах;

ж/. Засгийн газраас тогтоосон хяналтын тоонд багтаан цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэнийг сонгон авах;

з/. цэргийн насны залуучуудад "Бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх" талаар авсан арга хэмжээ, сургалт явуулсан тухай тайланг сумдын Ерөнхий боловсролын сургуулийн насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтнээс авах, урд онуудад цэрэг татлагын товчоогоор орж өвчний улмаас чөлөөлөгдсөн залуучуудын өвчлөл, тэдгээрийг эрүүлжүүлсэн тухай тайланг хүн тус бүрээр сумдын Эрүүл мэндийн төвийн их эмчээр гаргуулан авах;

4. Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

а/. цэрэг татлагын комиссын эмч нарын эрүүл мэндийн үзлэгээр цэргийн насны залуучуудыг зохион байгуулан оруулахдаа баг тус бүрээр нь 5-аас дээшгүй залуучуудыг нэг дор оруулах, үзлэгээр орж байгаа болон гадна байгаа хүн тус бүрийн хоорондын зайг 1.5 метрээс 2 метрийн зайтай зогсоох, тус үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг чанд сахиулах, улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэрийг чанд мөрдөж ажиллах, цэрэг татлага явуулах байрыг заавар, журмын дагуу бэлтгэх;

б/. цэрэг татлагын товчоогоор орох цэргийн насны иргэдэд зарлан дуудах мэдэгдлийг албан ёсоор хүргүүлэх, тэдгээрийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-д заасны дагуу шинжилгээний бичиг, баримтыг бэлтгүүлсэн байх, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт орох залуучуудыг тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байранд бэлэн байлгах;

в/. багийн Засаг дарга нар өөрсдийн багийн цэргийн насны залуучуудыг удирдан зохион байгуулан оролцуулах;

г/. цэрэг татлагын товчоогоор ороогүй цэргийн үүрэгтэнг эрэн сурвалжилж шалтгааныг тодруулан хүн нэг тус бүрээр тооцон гаргаж Цэргийн штабт өгөх;

5. Цэрэг татлагын байранд ажиллах албан тушаалтнуудыг нэгдүгээр хавсралтаар, цэрэг татлага явуулах хугацааг хоёрдугаар хавсралтаар, зардлын төсвийг эдийн засгийн тооцоонуудын хамт гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

6. Тус үйл ажиллагааны зардал 11,769,552 (Арван нэгэн сая долоон зуун жаран есөн мянга таван зуун тавин хоёр) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц

хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д зөвшөөрсүгэй.

7. Цэрэг татлагын товчооны албан ажлын хэрэгцээнд суудлын автомашин гаргаж үйлчлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Доржбат)-д, Цэргийн штабын захиалгын дагуу сумдын цэргийн цэргийн насны залуучуудад нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг хийх бүрэлдэхүүнийг унааны хамт гаргахыг, цэргийн албанд тэнцсэн иргэдэд шинжилгээ, үзлэгт хамруулахад шаардлагатай рентген, шүд, сэтгэцийн кабинетууд, эхо, эмнэлзүйн лаборатори, хяналтын үзлэг хийхэд шаардлагатай нарийн мэргэжлийн эмч нарыг 2021 оны 10 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Төрийн албаны тухай хуулийн 37.1.18, Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор баталсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам" –д заасны дагуу ажилуулахыг Эрүүл мэндийн газрын дарга (Б.Алтантөгс) Нэгдсэн эмнэлгийн дарга (Х.Жаргал)-д тус тус үүрэг болгосугай.

8. Цэрэг татлагын үеэр сумдад болон аймгийн төвд гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажил зохион байгуулахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхбат)-д даалгасугай.

9. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг цэрэг татлагын товчоонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ